



## ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ БАТЛАГДСАНЫ 60 ЖИЛИЙН ОЙ

Хүний үндсэн эрх, эрх чөлөөг 30 зүйлээр зөвшөөрсөн ХЭТТ-ыг 1948 оны 12 дугаар сарын 10-нд НҮБ-ын гишүүн орнууд баталсан билээ. Энэ нь анх засгийн газрын санаачилга байсан бол одоо дэлхий даяархи хүн бүрийн нийтлэг зорилт болоод байна. Эмнести Интернэшнл кампанит ажлаараа хүн бүр эрхээ эдэлдэг бодит ертөнц бий болгохын төлөө эрх баригч нарт амлалтыг нь сануулж, хариуцлага тооцон ажиллах болно.

**ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ**



**ЗҮЙЛ 1.** Хүн бүр төрж мэндлэхдээ эрх чөлөөтэй, адилхан нэр төртэй ижил эрхтэй байдаг. Оюун ухаан, нандин чанар заяасан хүн гэгч өөр хоорондоо ахан дүүсийн үзэл санаагаар харьцах учиртай.

**ЗҮЙЛ 2.** Хүн бүр энэ тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг ямар ч ялгаваргүйгээр яс үндэс, арьс өнгө, хүйс, хэл шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа бусад ялгааг эс харгалзан адилхан эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүний харьяалдаг улс орон буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй буюу олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тэрхүү нутаг дэвсгэр нь тусгаар тогтносон, бусдын асрамжинд байгаа, өөртөө захиргаагүй буюу бүрэн эрхт байдал нь хязгаарлагдмал байсан хүнийг ялгаварлаж үл болно.

**ЗҮЙЛ 3.** Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.

**ЗҮЙЛ 4.** Хэнийг ч боолчлол буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Боолчлол болон боолын худалдааны бүх төрлийг хориглоно.

**ЗҮЙЛ 5.** Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно.

**ЗҮЙЛ 6.** Хүн бүр хаана ч байсан эрх зүйн этгээд байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

**ЗҮЙЛ 7.** Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа үйлдэл, ялгаварлан гадуурхах явдал, тэгж ялгаварлан гадуурхах аливаа турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.

**ЗҮЙЛ 8.** Үндсэн хууль, бусад хуулиар олгосон эрх зөрчигдвөл хүн бүр шүүхээр эрхээ сэргээн тогтоолгох эрхтэй.

**ЗҮЙЛ 9.** Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.

**ЗҮЙЛ 10.** Хүн бүр эрх үүргээ тодорхойлуулах, эрүүгийн ял тулгавал тэр нь хир зэрэг үндэслэлтэй болохыг тогтоолгохын тулд тухайн хэргийг бүрэн тэгш эрхийн үндсэн дээр ил тод байдлаар, шударга ёсны бүх шаардлагын дагуу бусдын нөлөөнд автагдаагүй, гагцхүү хуулинд захирагдах шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

**ЗҮЙЛ 11.** 1. Гэмт хэрэгт яллагдаж буй хүн бүр өөрт нь тулгасан хэргийг өмгөөлүүлэх буюу өөрөө өмгөөлөх бүрэн боломжтойгоор шүүх хурлаар хэлэлцэн таслаж, хуулийн дагуу гэм буруутай нь тогтоогдох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй. 2. Тухайн үеийн үндэсний хууль тогтоомж буюу олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэл хийсэн буюу хийгээгүйг үндэслэж хэнийг ч гэмт хэрэгт яллан шийтгэх ёсгүй. Түүнчлэн гэмт хэрэг гарсан тэр үед ноогдуулж болох байснаас илүү хүнд ял тохоож болохгүй.

**ЗҮЙЛ 12.** Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нь нууц эсвэл нэр төр, алдар хүндэд нь дураар халдах ёсгүй. Тэгж оролцох, тийнхүү халдах гэвэл хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.

**ЗҮЙЛ 13.** 1. Хэн ч бай улс орны дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгон авах эрхтэй. 2. Хэн ч бай аль ч улсыг, түүнчлэн эх орноо орхин явах, эргэж очих эрхтэй.

**ЗҮЙЛ 14.** 1. Хэн боловч мөрдөлт мөшигилтөөс зугтаж өөр улс оронд орогнох боломжийг эрэлхийлэх, тийнхүү орогнох эрхтэй. 2. Улс төрийн бус гэмт хэрэг үйлдсэн, эсвэл Нэгдсэн Үндэсний Байгууллагын зорилго, зарчимд харш хэрэг үйлдсэний улмаас зайлшгүй мөрдөгдөж буй тохиолдолд дээрх эрхийг эдэлж үл болно.

**ЗҮЙЛ 15.** 1. Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй. 2. Аль ч хүний иргэний харьяаллыг буюу харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн хасах ёсгүй.

**ЗҮЙЛ 16.** 1. Насанд хүрсэн эрэгтэй эмэгтэй хүмүүс арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэгийн хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Тэд гэрлэхдээ, гэрлэснийхээ дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдэлнэ. 2. Эрэгтэй эмэгтэй хоёр чөлөөтэй харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно. 3. Гэр бүл нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.

**ЗҮЙЛ 17.** 1. Хүн бүр эд хөрөнгийг хувьдаа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй. 2. Хэний ч эд хөрөнгийг дураар хураан авч болохгүй.

**ЗҮЙЛ 18.** Хүн бүр чөлөөтэй сэтгэх, шүтэж бишрэх, сүсэглэх эрхтэй. Энэ нь шашин шүтлэг буюу үзэл бодлоо өөрчлөх эрх, ганцаараа буюу бусадтай хамтран нийтийн болон хувийн журмаар шашин шүтлэг, үзэл бодлоо заан түгээх, мөргөл хийх, сургаал гүйцэтгэх, шашны зан үйлийн ёслол үйлдэх эрхийг хамарна.

**ЗҮЙЛ 19.** Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, үүнд үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл харгалзан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх багтана.

**ЗҮЙЛ 20.** 1. Хүн бүр тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй. 2. Хэнийг ч эвсэл холбоонд албадан оруулах ёсгүй.

**ЗҮЙЛ 21.** 1. Хүн бүр улс орноо удирдах шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй. 2. Хүн бүр улс орондоо төрийн алба хаших тэгш эрхтэй. 3. Ард түмний хүсэл зориг бол засаглалын үндэс мөн: энэ нь бүх нийтэд сонгуулийн тэгш эрх эдлүүлэх үндсэн дээр саналыг нууцаар хураах, эсвэл саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц бусад замаар тогтмол, хуурамч бус сонгууль явуулахад илрэлээ олно.

**ЗҮЙЛ 22.** Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмээс хангамж авах эрхтэй бөгөөд нэр төрөө хамгаалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм соёлын эрх дархаа тухайн улс орны хүчин чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны нөөц бололцоонд нийцүүлэн эдлэх эрхтэй.

**ЗҮЙЛ 23.** 1. Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс сэргийлэн хамгаалуулах эрхтэй. 2. Хүн бүр ямар ч ялгаваргүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй. 3. Ажил хөдөлмөр эрхлэж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсгэврээр нэмэн аривуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй хөлс авах эрхтэй. 4. Хүн бүр эрх ашгаа хамгаалуулах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэх эрхтэй.

**ЗҮЙЛ 24.** Хүн бүр ажлын цагийг зохистойгоор хязгаарлахыг шаардах, цалинтай тогтмол амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй.

**ЗҮЙЛ 25.** 1. Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амжиргаатай байх, ажилгүйдэл, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй. 2. Баталгаатай гэр бүлээс гарсан болон бутач хүүхэд ялгаагүй нийгмээр адилхан хамгаалуулна.

**ЗҮЙЛ 26.** 1. Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Наад зах нь анхан шатны боловсролтой байх шаардлагатай. Техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээмжтэй байх ёстой. Авьяас чадварыг нь үндэслэн хүн бүрт дээд боловсрол эзэмших боловсролыг нь адилхан олгох ёстой. 2. Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болгоход чиглэгдэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биенээ ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн НҮБ-аас энх тайвныг сахин хамгаалах талаар явуулж буй үйл ажилгаанд дөхөм үзүүлэх ёстой. 3. Бага насны хүүхдийн боловсролын чиглэлийг сонгоход эцэг эх давуу эрх эдэлнэ.

**ЗҮЙЛ 27.** 1. Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох урлагийг бахдах шинжлэх ухааны дэвшилд оролцох үр шимийг нь хүртэх эрхтэй. 2. Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны үр шимийг хүртэж ашиг сонирхлоо хамгаалуулах эрхтэй.

**ЗҮЙЛ 28.** Хүн бүр энэ Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдэлж болохуйц тийм нийгмийн байгууламж болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй.

**ЗҮЙЛ 29.** 1. Хүн бүр нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангана. 2. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана. 3. Эдгээр эрх, эрх чөлөөг НҮБ-ын зорилго зарчимд харшуулан эдлэх ёсгүй.

**ЗҮЙЛ 30.** Энэхүү Тунхаглалын ямар ч зүйл ангийг аль нэг улс орон, бүлэг буюу бие хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг үгүйсгэхэд чиглэсэн аливаа ажиллагаа явуулах, тийм үйлдэл хийх эрх, бололцоо олгож байгаа мэтээр мушгин ойлгож болохгүй.